БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангүй тайлан

**Аудитын код: БНА-2026/129/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Баянхонгор<br>2025 оны 02 дугаар сарын 25 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Нарангэрэл<br>Утас: 99009293 Цахим хаяг: narangerel batmunkh@audit.gov.mn<br>Баян ташаагийн эх аудит захирал т.Хоролсүрэн<br>Утас:99116028 Цахим хаяг: t.khorolsuren@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 6
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 12
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 16
**4.1 Ерөнхий зүйл** ........ 16
**4.2 Материаллаг байдал** ........ 17
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 17
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 17
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 17
**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 17
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 18
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 21

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсандандзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/76

танай ______________-ны № ______________ -т

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Г.СҮХБААТАР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

Өмнөх оны 2021 оны аудитаар тогтоогдсон 3,311.9 мянган төгрөгийн албан шаардлагаас буруутай албан хаагчаар төлүүлэх 1,111.9 мянган төгрөгийн үлдэгдэл төлбөрийг барагдуулаагүй зөрчил нь шинж чанар хувьд материаллаг бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан

6426050234

шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй. Тайланд онд 1,099,715.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлийн санхүүжилт 1,049,151.5 мянган төгрөг авч, 1,051,216.6 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 1 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 88 хувиар үнэлсэн байна.

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **188,086,306.79** | **104,172,983.45** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 17,372,138.72 | 15,306,971.52 |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 17,372,138.72 | 15,306,971.52 |
| **31210** | **Төгрөг** | 17,372,138.72 | 15,306,971.52 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 17,372,138.72 | 15,306,971.52 |
| **32** | **АВЛАГА** | 102,733,994.64 | 20,808,062.13 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 102,733,994.64 | 20,808,062.13 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 67,980,173.43 | 68,057,949.80 |
| **35100** | **Түүхий эд материал** | 48,879,389.09 | 50,053,902.52 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 43,470,203.28 | 41,086,316.66 |
| 35130 | Эм боох материал | 5,409,185.81 | 8,967,585.86 |
| **35400** | **Хангамжийн материал** | 19,100,784.34 | 18,004,047.28 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 961,300.00 | 1,390,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 17,010,500.00 | 14,756,299.00 |
| 35440 | Шатах,тослох мөтериөл | 1,033,384.34 | 717,578.28 |
| 35460 | Хүнсний материал | 95,600.00 | 1,140,070.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **951,586,065.67** | **829,187,330.21** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 951,586,065.67 | 829,187,330.21 |
| **39200** | **Биет хөрөнгө** | 929,424,065.67 | 807,025,330.21 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 453,756,058.00 | 453,756,058.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (54,913,858.76) | (63,908,894.84) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 321,920,616.47 | 321,920,616.47 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (55,946,940.30) | (110,731,782.78) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 332,367,690.51 | 306,062,316.76 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (111,132,592.95) | (131,234,635.98) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 68,002,064.90 | 59,236,064.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (25,985,272.49) | (29,749,679.33) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,938,000.00 | 1,392,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (12,151,699.71) | (707,232.99) |
| 39217 | Ном | 570,000.00 | 990,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **22,162,000.00** | **22,162,000.00** |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (450,000.00) | (450,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 22,162,000.00 | 22,162,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,139,672,372.46** | **933,360,313.66** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **29,064,810.00** | |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 29,064,810.00 | |
| **413** | **Өглөг** | 29,064,810.00 | |
| **4136** | **Бусад өглөг** | 29,064,810.00 | |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 29,064,810.00 | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,110,607,562.46** | **933,360,313.66** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,110,607,562.46 | 933,360,313.66 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 580,017,310.00 | 580,017,310.00 |
| 51101 | Өмч - төрийн | 580,017,310.00 | 580,017,310.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 461,671,642.91 | 284,424,394.11 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 461,671,642.91 | 461,671,642.91 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (177,247,248.80) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 68,918,609.55 | 68,918,609.55 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,139,672,372.46** | **933,360,313.66** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,286,092,314.77** | **975,880,235.06** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **384,009,819.58** | **8,604,840.06** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 384,009,819.58 | 8,604,840.06 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 364,121,026.74 | 7,711,427.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 47,135,000.00 | 3,410,327.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **902,082,495.19** | **967,275,395.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 41,111,300.00 | 58,561,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 41,111,300.00 | 58,561,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 860,971,195.19 | 908,713,795.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 860,971,195.19 | 908,713,795.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **987,898,231.00** | **1,153,127,483.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **987,898,231.00** | **1,153,127,483.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 986,457,498.34 | 1,149,667,288.32 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 599,490,234.30 | 722,880,503.80 |
| 210101 | Үндсэн цалин | 367,144,496.85 | 419,049,268.17 |
| 210102 | Нэмэгдэл | 173,305,247.45 | 214,487,345.63 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,438,000.00 | 27,330,000.00 |
| 210104 | Урамшуулал | 53,602,490.00 | 62,013,890.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 75,373,201.90 | 90,624,821.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,374,529.41 | 61,443,921.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,021,302.30 | 7,252,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,718,699.86 | 3,626,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,849,632.44 | 3,626,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,409,037.89 | 14,675,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **38,139,067.34** | **46,303,404.46** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,533,729.34 | 4,189,853.56 |
| 210302 | Түлш, халаалт | 33,410,898.00 | 41,849,350.90 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 194,440.00 | 264,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **81,698,191.51** | **55,604,180.74** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,532,600.00 | 4,124,560.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,147,435.44 | 27,372,169.06 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,311,300.00 | 1,358,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 280,000.00 | 700,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,786,319.49 | 10,287,902.65 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 45,640,536.58 | 11,760,049.03 |
| **2105** | **Нормативт зардал** | **94,536,466.83** | **62,918,535.95** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 85,304,316.83 | 55,353,415.95 |
| 210502 | Хоол, хүнс | 8,842,150.00 | 7,565,120.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 390,000.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **19,846,396.00** | **10,911,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,184,500.00 | 66,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 18,661,896.00 | 10,845,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,500,000.00** | **9,020,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,500,000.00 | 9,020,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | **1,095,320.00** | **16,638,606.11** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 13,422,608.11 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 1,200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,900.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 172,420.00 | 337,713.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 748,000.00 | 1,255,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 346,285.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **72,778,620.46** | **134,765,735.46** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 725,100.00 | 2,346,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 72,053,520.46 | 132,419,735.46 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,440,732.66** | **3,460,195.54** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,440,732.66** | **3,460,195.54** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,440,732.66 | 3,460,195.54 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **298,194,083.77** | **(177,247,248.80)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **138,000.00** | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 138,000.00 | |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(138,000.00)** | |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН** | **298,056,083.77** | **(177,247,248.80)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **849,147,120.55** | **1,052,611,654.51** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **47,135,000.00** | **3,410,327.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 47,135,000.00 | 3,410,327.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 47,135,000.00 | 3,410,327.00 |
| 120002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 47,135,000.00 | 3,410,327.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **802,012,120.55** | **1,049,201,327.51** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 41,111,300.00 | 58,561,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 41,111,300.00 | 58,561,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 760,900,820.55 | 990,639,727.51 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 760,900,820.55 | 990,639,727.51 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **808,103,456.20** | **1,048,956,921.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **808,103,456.20** | **1,048,956,921.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **806,662,723.54** | **1,045,496,726.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **598,217,722.71** | **722,880,503.80** |
| 210101 | Үндсэн цалин | 362,737,490.21 | 426,544,232.85 |
| 210102 | Нэмэгдэл | 173,623,719.14 | 207,376,751.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,427,000.00 | 27,284,498.57 |
| 210104 | Урамшуулал | 56,429,513.36 | 61,675,020.58 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **76,645,713.49** | **90,624,821.80** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,729,613.49 | 61,443,921.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,247,000.00 | 7,252,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,997,600.00 | 3,626,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,177,600.00 | 3,626,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,493,900.00 | 14,675,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **38,175,567.34** | **46,303,404.46** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,533,729.34 | 4,189,853.56 |
| 210302 | Түлш, халаалт | 33,410,898.00 | 41,849,350.90 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 230,940.00 | 264,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **33,925,800.00** | **40,153,360.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,008,800.00 | 4,714,460.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,000,000.00 | 29,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,411,300.00 | 1,340,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,305,700.00 | 916,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,200,000.00 | 3,682,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **44,891,600.00** | **101,612,231.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 36,068,600.00 | 86,922,541.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,823,000.00 | 10,101,690.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 4,588,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,569,400.00** | **13,034,299.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,107,500.00 | 1,287,999.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,461,900.00 | 11,746,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,500,000.00** | **9,020,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,500,000.00 | 9,020,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **846,220.00** | **16,568,106.11** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 13,664,608.11 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,900.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 172,420.00 | 200,213.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 498,900.00 | 1,080,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 346,285.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **890,700.00** | **5,300,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 890,700.00 | 5,300,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,440,732.66** | **3,460,195.54** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,440,732.66** | **3,460,195.54** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | **1,440,732.66** | **3,460,195.54** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **41,043,664.35** | **3,654,732.80** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **25,019,249.00** | **5,719,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **25,019,249.00** | **5,719,900.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 25,019,249.00 | 5,719,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 25,019,249.00 | 5,719,900.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(25,019,249.00)** | **(5,719,900.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **16,024,415.35** | **(2,065,167.20)** |
| **101** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **1,347,723.37** | **17,372,138.72** |
| **20** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **17,372,138.72** | **15,306,971.52** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **580,017,310.00** | **68,918,609.55** | **163,615,559.14** | **812,551,478.69** |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **580,017,310.00** | **68,918,609.55** | **163,615,559.14** | **812,551,478.69** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 298,056,083.77 | 298,056,083.77 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **580,017,310.00** | **68,918,609.55** | **461,671,642.91** | **1,110,607,562.46** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **580,017,310.00** | **68,918,609.55** | **461,671,642.91** | **1,110,607,562.46** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **580,017,310.00** | **68,918,609.55** | **461,671,642.91** | **1,110,607,562.46** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -177,247,248.80 | -177,247,248.80 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **580,017,310.00** | **68,918,609.55** | **284,424,394.11** | **933,360,313.66** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,099,715,900.00** | **1,051,216,526.97** | **50,564,441.03** | **95.4** |
| 310002 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **58,561,600.00** | **55,101,404.46** | **3,460,195.54** | **94.1** |
| | Орон нутгийн төсвөөс | 58,561,600.00 | 55,101,404.46 | 3,460,195.54 | 94.1 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,020,407,000.00** | **990,639,727.51** | **29,767,272.49** | **97.1** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,020,407,000.00 | 990,639,727.51 | 29,767,272.49 | 97.1 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **20,747,300.00** | **3,410,327.00** | **17,336,973.00** | **16.4** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,375,200.00 | 3,410,327.00 | (35,127.00) | 101.0 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 17,372,100.00 | 2,065,167.20 | 15,306,972.80 | |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,099,715,900.00** | **1,051,216,626.17** | **48,499,273.83** | **95.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,099,715,900.00** | **1,051,216,626.17** | **48,499,273.83** | **95.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,099,715,900.00** | **1,051,216,626.17** | **48,499,273.83** | **95.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **741,726,400.00** | **722,880,503.80** | **18,845,896.20** | **97.5** |
| 210101 | Үндсэн цалин | 463,529,800.00 | 426,544,232.85 | 36,985,567.15 | 92.0 |
| 210102 | Нэмэгдэл | 185,809,000.00 | 207,376,751.80 | (21,567,751.80) | 111.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 28,094,600.00 | 27,284,498.57 | 810,101.43 | 97.1 |
| 210104 | Урамшуулал | 64,293,000.00 | 61,675,020.58 | 2,617,979.42 | 95.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **92,448,000.00** | **90,624,821.80** | **1,823,178.20** | **98.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,178,800.00 | 61,443,921.80 | 734,878.20 | 98.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,567,300.00 | 7,252,600.00 | 314,700.00 | 95.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,783,700.00 | 3,626,300.00 | 157,400.00 | 95.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,783,700.00 | 3,626,300.00 | 157,400.00 | 95.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,134,500.00 | 14,675,700.00 | 458,800.00 | 97.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,561,600.00** | **46,303,404.46** | **3,258,195.54** | **93.4** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,500,000.00 | 4,189,853.56 | 1,310,146.44 | 76.2 |
| 210302 | Түлш, халаалт | 43,561,600.00 | 41,849,350.90 | 1,712,249.10 | 96.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 264,200.00 | 235,800.00 | 52.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **40,709,900.00** | **40,573,360.00** | **136,540.00** | **99.7** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,716,100.00 | 4,714,460.00 | 1,640.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,500,600.00 | 29,500,000.00 | 600.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,457,100.00 | 1,340,800.00 | 116,300.00 | 92.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 420,000.00 | 420,000.00 | | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 916,100.00 | 916,100.00 | | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,700,000.00 | 3,682,000.00 | 18,000.00 | 99.5 |
| **2105** | **Нормативт зардал** | **112,220,700.00** | **101,612,231.00** | **10,608,469.00** | **90.5** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 93,025,600.00 | 86,922,541.00 | 6,103,059.00 | 93.4 |
| 210502 | Хоол, хүнс | 14,395,100.00 | 10,101,690.00 | 4,293,410.00 | 70.2 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,800,000.00 | 4,588,000.00 | 212,000.00 | 95.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,000,000.00** | **18,334,199.00** | **1,665,801.00** | **91.7** |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 6,587,899.00 | 1,412,101.00 | 82.3 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,000,000.00 | 11,746,300.00 | 253,700.00 | 97.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **10,000,000.00** | **9,020,000.00** | **980,000.00** | **90.2** |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,000,000.00 | 9,020,000.00 | 980,000.00 | 90.2 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **27,749,300.00** | **16,568,106.11** | **11,181,193.89** | **59.7** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,159,300.00 | 13,664,608.11 | 10,494,691.89 | 56.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,200,000.00 | 1,200,000.00 | | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 430,000.00 | 00.00 | 430,000.00 | 0.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 404,000.00 | 200,213.00 | 203,787.00 | 49.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 126,000.00 | 77,000.00 | 49,000.00 | 61.1 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,080,000.00 | 1,080,000.00 | | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 350,000.00 | 346,285.00 | 3,715.00 | 98.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,300,000.00** | **5,300,000.00** | | **100.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,300,000.00 | 5,300,000.00 | | 100.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 17,372,138.72 | (17,372,138.72) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 15,306,971.52 | (15,306,971.52) | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **25** | **25** | | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16 | 16 | | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **25** | **25** | | **100.0** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 16 | 16 | | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 9 | 9 | | 100.0 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2021 оны аудитаар тогтоогдсон 3,311.9 мянган төгрөгийн албан шаардлагаас буруутай албан хаагчаар төлүүлэх 1,111.9 мянган төгрөгийн үлдэгдэл төлбөрийг барагдуулаагүй тул Хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

### Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/Мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өмнөх оны 2021 оны аудитаар тогтоогдсон 3,311.9 мянган төгрөгийн албан шаардлагаас буруутай албан хаагчаар төлүүлэх 1,111.9 мянган төгрөгийн үлдэгдэл төлбөрийг барагдуулаагүй байна. | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |